


Нэгдүгээр хэсэг.
WORDPRESS ПРОГРАММЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1-р бүлэг

WordPress программыг танилцуулах нь

- 1.1 WordPress программын давуу талууд
- 1.2 WordPress.org болон WordPress.com, тэдгээрийн ялгаа
- 1.3 WordPress программыг ашиглан хийх вэб сайтууд
- 1.4 WordPress вэб сайтын чухал элементүүд



1-р бүлэг. WordPress программыг танилцуулах нь

1.1 WordPress программын давуу талууд

Үнэгүй программ. WordPress-ийг ашиглахыг хүссэн хүн бүр программын хамгийн сүүлийн хувилбарыг www.wordpress.org вэб сайтаас ямар ч төлбөр хийлгүйгээр татан хэрэглэж болно.

Сурахад хялбар. Та вэб сайт бүтээх талаар мэдлэг байхгүй, Агуулах Удирдах Системтэй ажиллаж байгаагүй ч WordPress программыг богино хугацаанд сурах боломжтой.

Ашиглахад амархан. WordPress нь Агуулах удирдах системүүд дотроос хэрэглэхэд хамгийн амархан систем юм. Иймээс та вэб сайтаа чадварлаг удирдах болно.

Брэнд вэб сайт бүтээх. WordPress программыг суулгаад анх ажиллуулахад танд энгийн бүтэцтэй вэб сайтыг байгуулж өгнө. Энгийн бүтэцтэй энэ вэб сайтыг та өөрийн бизнест нийцсэн онцлог дизайнтай брэнд сайт болгон өөрчлөх бүрэн бололцоотой.

Байнга шинэчлэгддэг систем. WordPress программ нь бусад Агуулга Удирдах Системүүдтэй харьцуулахад хамгийн хурдацтай хөгжиж байгаа систем юм. WordPress программын шинээр гарах хувилбарууд нь түүний ажиллагааг улам боловсронгуй болгосоор байна.

Нэмэгдэл программыг хэрэглэх. Цахим худалдаа ажиллуулах, нээлттэй хэлэлцүүлэг явуулах, видео оруулах, гишүүн элсүүлэх зэрэг вэб сайтын ажиллагааг өргөжүүлэхэд хэрэгтэй нэмэлт программууд болох плагинуудыг өргөнөөр сонгон ашиглах бололцоотой.

WordPress-ийн талаар тусламж авах. Вэб сайтыг найдвартай ажиллуулах, өргөтгөх, вэбийн админ хэсэг рүү муу хүмүүс нэвтрэхээс хамгаалах зэрэг олон асуудлуудаар тусламж авах хэрэгтэй бол та ганцаардахгүй. Танд WordPress-ийн мэргэжилтэн, туршлагатай хэрэглэгч, мэргэжлийн зөвлөгч нараас тусламж авах үүд байнга нээлттэй байна. Үүнээс гадна WordPress-ийг ажиллуулах тухай олон тооны ном, сурах бичиг, вэб сайтууд бүтээгдсэн. Үүний нэг нь WordPress-ийн өөрийнх нь Codex вэб хуудас зүй ёсоор орно.

1.2 WordPress.org болон WordPress.com, тэдгээрийн ялгаа

WordPress программыг ашиглан вэб сайтаа хоёр замаар байгуулах боломжтой.

- * www.wordpress.org вэб рүү орж WordPress программын сүүлийн хувилбарыг вэб сервер дээр татан суулгах
- * www.wordpress.com вэбд гишүүнээр элсэн блог үүсгэх эрхтэй болох

Энэ номонд эхний буюу WordPress программын сүүлийн хувилбарыг ашиглан вэб сайт бүтээх тухай оруулсан болно.

Доор байгаа хүснэгтэд wordpress.org болон wordpress.com –ийн зарим гол ялгаануудыг харьцуулан харууллаа.

www.wordpress.com вэб сайтыг WordPress-ийг үндэслэгч Matt Mullenweg-ийн Automattic компани эрхлэн ажиллуулдаг юм. Өөрөөр хэлбэл энэ вэб сайт дээр WordPress программыг суулгасан бөгөөд хүссэн хүн бүр уг вэб сайтад бүртгүүлж блог үүсгэх боломжтой.

	WordPress-ийн хувилбарууд	
	www.wordpress.org	www.wordpress.com
Зорилго	Бизнесийн болон томоохон хэмжээний вэб сайт ажиллуулах зорилготой бол WordPress программын бие даасан энэ хувилбарыг сонгоорой.	Хувийн блог үүсгэх зорилготой бол WordPress программыг суулгасан www.wordpress.com вэбд гишүүнээр элсэж блог үүсгэх эрхтэй болоорой.
WordPress-ийг суулгах	Вэб сайтаа байрлуулах сервер дээр WordPress программыг суулгана.	WordPress программыг суулгах шаардлага байхгүй. www.wordpress.com вэб сайтад бүртгүүлж гишүүн болно.
Вэб сайтыг удирдах,	Вэб сайтыг удирдаж агуулга оруулах, зохион байгуулах, хадгалах, засах, устгах, муу хүмүүсээс хамгаалах бүхий л ажлыг өөрсдөө хийнэ.	Блогт агуулгыг өөрсдөө оруулж, засах болон устгана. Харин блогийн найдвартай ажиллагааг www.wordpress.com хариуцна.
Вэб сайтын дизайныг сонгох	WordPress вэб сайтад зориулж хийгдсэн бэлэн вэб загваруудаас дуртайгаа шилэн ашиглаж болно. Мөн вэб сайтаа тохирох загвараа өөрөө шинээр зохиох боломжтой.	Зөвхөн www.wordpress.com дээр байгаа вэб дизайны загвараас сонгон хэрэглэх боломжтой.
WordPress-ийг шинэчлэх	WordPress программын шинэ хувилбар гарах бүрт өөрсдөө суулгана.	www.wordpress.com нь WordPress программын шинэчлэлийг дор бүр хийнэ.
Виджет ашиглах	WordPress программд зориулсан виджет болгоныг хэрэглэх боломжтой.	www.wordpress.com дээр байгаа вэбийн загвараас хамаарч виджетийг хэрэглэнэ.
Плагин ашиглах	WordPress программд зориулан зохиогдсон плагин болгоныг хэрэглэх боломжтой.	Плагиныг шинээр суулгах боломжгүй.

1.3 WordPress программыг ашиглан хийх вэб сайтууд

WordPress программыг ашиглан янз бүрийн зорилготой вэб сайтуудыг байгуулж ажиллуулах бүрэн бололцоотойгоос заримаас нь цухас дурдъя.

Блог. WordPress нь анх блог үүсгэх зорилгоор бүтээгдсэн бөгөөд үнэхээр ч блог үүсгэх олон программууд дотроос хамгийн шилдэгт маргаангүй тооцогдоно. Өөрийн дуртай сэдвээр болон өдрийн тэмдэглэл хөтлөх гэх мэт төрөл бүрийн сэдэвтэй блогуудыг үүсгэхэд WordPress-ийг ашиглах нь оновчтой сонголт болно.

Мэдээллээр баялаг вэб сайт. Бизнес эрхлэгчид өөрсдийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэлээ, олон нийтийн байгууллага болон холбоод ажил зорилгынхоо талаар сурталчлан танилцуулахад WordPress-ийг ашиглах нь хамгийн хэмнэлттэй байх болно.

Цахим худалдаа хийх вэб сайт. WordPress-ийг ашиглан жижиг болон дунд хэмжээний цахим худалдаа хийх вэб сайтыг байгуулж, бараа бүтээгдэхүүн, цахим бүтээлийн худалдаа эрхэлж байгууллага, өрхийн орлогоо нэмэгдүүлээрэй.


Гишүүн элсүүлэх вэб сайт. Цахим худалдаа, онлайн сургалт болон бусад үйлчилгээг явуулахдаа олон нийтийг өөрийн гишүүнээр вэб сайтдаа элсүүлэн, тэдгээрт гишүүний тусгай эрхийг эдлүүлэх, хөнгөлөлт үзүүлэх, харилцаа тогтоох зэрэг чадварлаг вэб сайтыг удирдахад WordPress танд туслана.

Байгууллагын дотоод сүлжээ. WordPress нь байгууллагын дотоод сүлжээг байгуулж, удирдахад сайн зохицох систем юм. Иймээс их дээд, сургууль, эмнэлэг, төрийн болон бусад албан байгууллагуудын мэдээллийн технологийн удирдлагууд дотоод сүлжээгээ хөгжүүлэхэд энэ системийг ашиглах боломжтой.

Дунд, томоохон хэмжээний хэлэлцүүлэгийн вэбүүд. Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгэмд хэрэгтэй шинэ санаачлага, ажил үйлс, гарч байгаа сөрөг талууд зэрэг олон сэдвүүдээр нээлттэй хэлэлцүүлэг явуулах вэбийг WordPress бүтээнэ.

Вэбийн сүлжээ. WordPress программыг нэг л удаа суулгаад түүнийг нэгдсэн удирдлага, хяналттай вэбийн сүлжээ болгон өргөтгөн хөгжүүлэх боломжтой.

Фото зураг болон видео цомгийн вэб сайт. Уран бүтээлчдийн бүтээлээ олон нийтэд толилуулах фото, уран зураг болон видео цомгийн сайтыг WordPress байгуулна.



WordPress программыг ашиглан бүтээгдсэн АНУ-ын алдартай CNN мэдээллийн агентлагийн вэб сайтын нүүр хуудас

Цахим номоо сурталчлах. Цахим хэвлэн нийтлэх WordPress технологи нь зохиолч, сэтгүүлч, оюуны уран бүтээлч хүн бүхнийг өөрийн бүтээлээ өөрөө сурталчилж, монголдоо төдийгүй дэлхий дахинд танил болгох цахим түгээлтийн систем болно.

Хөдөлгөөнт вэб сайт. Орчин үеийн мэдээлэл технологийн гайхамшигт бүтээлүүд болох таблет, гар утас зэрэг цахим төхөөрөмжүүд дээр WordPress вэб сайтыг зохимжтой загварт оруулан агуулгыг нь бүрэн унших хөдөлгөөнт вэб сайт болгон хөрвүүлэх боломжтой. WordPress хөдөлгөөнт вэб сайтаа та хаа ч явсан ашиглаж бизнесээ удирдан зохицуулах болно.

Их, дээд, дунд сургуулийн вэб сайт. Сургууль, цэцэрлэгийн бяцхан хүүхдүүдийн оюун ухааныг хөгжүүлэхэд хэрэгтэй вэб сайт хийх хүсэлтэй багш, сурагчдын зорилгыг WordPress бүрэн дэмжинэ.

Тусгай зорилготой бие даасан төслүүдийг зохицуулах вэб. Урт богино хугацааны бие даасан төслүүдийн тухай мэдээлэл, төслийг удирдан хэрэгжүүлэх, мэдээллийг солилцоход шаардлага хангах вэбийг бүтээхэд WordPress-ийг сонгоход алдахгүй.

1.4 WordPress вэб сайтын чухал элементүүд

WordPress нь энгийн ажиллагаатай вэб сайтыг байгуулах, удирдахад хэрэгтэй элементүүдийг багтаасан программ юм. WordPress-т зориулан хийгдсэн плагин програмууд болон бусад олон тооны виджетүүдийг нэмэн суулгаж энгийн энэ вэб сайтыг нарийн ажиллагаатай томоохон бизнесийн вэб болгон хөгжүүлнэ. WordPress программын чухал элементүүдийг одоо товчхон танилцуулъя. Дараагийн бүлгүүдэд уг элементүүдийг дэлгэрэнгүй танилцуулах болно.

Бичлэг(Post). Өдөр тутмын мэдээ, тодорхой сэдэв бүхий өгүүллэг, үйл явдлын тухай мэдээлэлүүд нь бичлэг болон орно. Бичлэгүүд үүссэн дарааллаараа үргэлжлэн цувж байрлана. Вэб сайтын нүүр хуудас дээр хамгийн сүүлд орсон бичлэг хамгийн эхэнд гарч ирнэ. Вэб сайтад орох бичлэгүүд нь байнга шинээр өөрчлөгдөн нэмэгдэн орох тул бичлэгийн агуулгыг динамик гэж үзнэ.

Хуудас(Page). Агуулгыг нь байнга өөрчлөх шаардлагагүй байгууллагын танилцуулга, ажлын дүрэм, холбоо барих мэдээлэлүүд нь хуудас үүсгэнэ. Хуудас нь бичлэг шиг орсон дарааллаар үргэлжлэн байрлахгүй. Вэбийн браузер дээр хуудас бүрийг дангаар нь дуудаж гаргаж ирнэ. Вэб сайтад үүсгэсэн хуудсуудын агуулгыг нэлээд хугацааны турш өөрчлөх шаардлагагүй тул агуулгыг нь статик гэж үзнэ.

Медиа агуулгууд(Media files). WordPress вэб сайтын агуулгыг текст төдийгүй зураг, видео, дуу, интерактив зэрэг медиа агуулгуудаар баяжуулах өргөн боломжтой. Түгээр ч барахгүй вэб сайтад зургийн цомог, видео цомог байрлуулж, Microsoft Word документ, PDF файлуудыг нээн уншиж болно.

Холбоос (Links). WordPress нь вэб сайтын нэг хэсгээс өөр хэсэг рүү орох, нэг хуудаснаас нөгөө хуудас руу болон өөр вэб сайт руу шууд ороход ашиглах холбоосуудыг амархан үүсгэнэ. Вэб сайтад оруулсан PDF, Word документ зэрэг нэмэгдэл агуулгуудын файлыг татах, нээж уншихад ашиглах холбоосыг мөн үүсгэнэ.

Ангилалууд (Categories). WordPress нь вэб сайтад орсон олон бичлэгүүдээс хэрэгтэй бичлэгийг хурдан олохын тулд, тэдгээрийг ангилал, дэд ангилалд оруулан зохион байгуулна.

Тэмдэглээ(Tags). Вэбд орсон бичлэгүүдийг ангилал үүсгэн зохион байгуулахаас гадна тэмдэглээ гэсэн чухал элементийг хэрэглэнэ. Бичлэг үүсгэхдээ тухайн бичлэгийн агуулгад орсон үгүүдээс чухал гэж үзсэн үг болон үгүүдийг сонгон тусад тэмдэглээ болгон оруулна. Тухайн тэмдэглээ үгийг ашиглан хайлт

хийхэд уг тэмдэглээг ашигласан бүх бичлэгүүд гарч ирнэ. Бичлэгүүдээс хэрэгтэйгээ ялган уншина.

Сэтгэгдэл(Comments). Вэб сайтын хэрэглэгч вэбийн тухай болон тухайн агуулгын талаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлж сэтгэгдлээ үлдээх боломжийг WordPress олгоно. Ингэснээр хэрэглэгчийн хэрэгцээг хангасан агуулгыг вэбд оруулах, хэрэглэгчтэй баттай холбоо тогтоох төдийгүй хэрэглэгчдийг хооронд нь холбох боломжийг WordPress бүрдүүлнэ.

Хэрэглэгчид(Users). WordPress нь вэб сайтын ажиллагаанд оролцож байгаа хэрэглэгчдийг гүйцэтгэх үүргийн дагуу удирдах боловсронгуй систем юм. WordPress нь вэб сайтад бүртгүүлсэн хэрэглэгчид админ, редактор, зохиогч, хамтрагч, уншигч гэсэн таван өөр түвшний ангилалд хуваагдана.

Спам хамгаалалт (Spam protection). Уншигчид сайтын агуулга, ажиллагааны талаар санал сэтгэгдлээ үлдээх боломжтой ч тэдгээр сэтгэгдэлүүдийн зарим нь вэб сайтын ажиллагааг саатуулах, зогсоох зорилготой спам сэтгэгдлүүд байна. Спамас сэргийлэхийн тулд WordPress программын бүрэлдэхүүнд спам илрүүлэх **Akismet** плагин хамт ирнэ.

Автомат шинэчлэл(Automatic upgrades). WordPress программ нь шинэ хувилбар болон тухайн хувилбарын шинэчлэл, мөн ашиглаж байгаа плагин болон вэбийн загварын шинэ хувилбар бүтээгдэх бүр эдгээрийг татан суулгаж, вэб сайтаа шинэчлэхийг сануулна.

Вэбийн загварууд (Themes). Вэб сайтын дизайныг WordPress сайтад зориулан хийгдсэн вэбийн бэлэн загваруудаас сонгон өөрчилж болно. Вэбийн загвар гэдэг нь WordPress сайтыг интернэт дээр өөрийн гэсэн өнгө үзэмж, дизайнтай харагдуулах, вэбийг саадгүй ашиглах, ажиллуулах багц файлуудыг хэлнэ

Үнэхээр Энгийн Синдикат (RSS-Really Simple Syndication). Энэ нэр томъёог өмнө нь сонсож байгаагүй бол санаа зовсны хэрэггүй. Энэ бол Синдикат буюу вэб сайт дээр нэмэгдсэн шинэ бичлэгүүдийг цаг алдахгүй унших боломжийг олгох интернетийн технологи юм. Вэб дээр тавигдсан шинэ бичлэгийг уншихын тулд хэрэглэгч уг вэб сайт руу заавал орох шаардлагагүй. Вэб дээр тавигдсан шинэ бичлэг **Google Reader** гэх мэт феед уншигч дээр синдикат хийгдэх буюу гарч ирнэ. Уншигч **Google Reader** дээр зөвхөн энэ вэбийн шинэ мэдээлэлийг уншихаас гадна бас бусад вэбүүдээс ирэх синдикат хийгдсэн мэдээллийг унших боломжтой. Өөрөөр хэлбэл уншигч вэб сайт болгон луу орж цагаа үрэлгүйгээр тэдгээр вэб сайтад нийтлэгдсэн шинэ бичлэгүүдийг нэг дороос уншина. Үнэхээр энгийн мөртлөө гайхалтай технологи.


Виджетүүд(Widgets). Вэб хуудас дээр холбоосын жагсаалт, навигацийн нэрсүүд, хамгийн сүүлд орсон бичлэгүүд, нэвтрэх мэдээлэлийг оруулах цонх, хайлт хийх хэсэг гэх мэтчилэн нэмэлт мэдээлэл гаргаж ирэх зориулалтаар виджетийг ашиглана. Виджетүүдийг вэбийн хажуу тал, төгсгөл хэсэг болон хаана ч гарч ирэхээр байрлуулж болно. .

Плагиинууд(Plugins). Цахим худалдаа ажиллуулах, гишүүн элсүүлэх, нээлттэй хэлэлцүүлэг явуулах, видео болон зургийн цомог үүсгэх, вэб сайтын файлуудыг тусгайлан хадгалах зэрэг вэб сайтын ажиллагааг өргөжүүлэх, сайтыг хамгаалах зорилгоор хэрэглэгддэг нэмэлт программ болох плагиинуудыг чөлөөтэй болон төлбөртэйгөөр сонгон ашиглах боломжтой.

2-р бүлэг

WordPress программыг ажиллуулах орчинг бүрдүүлэх

- 2.1 WordPress программыг суулгах аргууд
- 2.2 WordPress программыг суулгах, ажиллуулах
техникийн шаардлагууд



2-р бүлэг. WordPress программыг ажиллуулах орчинг бүрдүүлэх

2.1 WordPress программыг суулгах аргууд

WordPress программыг ажиллуулахын тулд түүнийг вэб сервер дээр суулгана.

Вэб сервер нь вэб сайтуудыг интернэт дээр ашиглуулах программ бөгөөд уг программыг суулгасан компьютерийг сервер компьютер гэнэ.

Ийм сервер компьютерийг ашиглан вэб сайт байрлуулах үйлчилгээ эрхэлдэг компаниудыг хостинг компаниуд гэнэ. Сервер компьютерууд нь олон зуун вэб сайтыг байрлуулж, тэдгээрийг ашиглуулах техникийн чадвартай байна.

Вэб сайтаа хаана байрлуулахаас хамаарч WordPress программыг дараах гурван аргаар суулгана.

Компьютер дээр WordPress-ийг суулгах. Одоогоор вэб сайтынхаа домайн нэрийг сонгоогүй, сайтаа өөрийнхөө компьютер дээр байгуулж турших зорилготой бол энэ аргыг сонгоорой. Энэ тохиолдолд вэб сайтыг зөвхөн ашиглаж байгаа компьютер дээр харж болох бөгөөд интернэтэд вэб сайтыг харж чадахгүй. Бид энэ аргыг ашиглан WordPress-ийг суулгаж ажиллуулна.

Хостинг Компанийн Сервер дээр WordPress-ийг суулгах. Домайн нэр, вэбээ байрлуулах хостоо сонгосон бол WordPress-ийг уг хостинг компаний онлайн сервер дээр суулгана. Мөн та интернетэд холбоотой вэб серверийн үүрэг гүйцэтгэх компьютертай бол түүн дээр WordPress-ийг татан суулгаж болно. Вэб сервер дээр WordPress-ийг суулгаснаар таны вэб сайт интернэт дээр шууд байрлаж хэрэглэгч нар хэдийд ч харж, унших боломжтой болно. Хостинг компанийн вэб сервер дээр WordPress-ийг суулгах нь компьютерт суулгасан сервер программ дээр WordPress-ийг суулгахтай адилхан.

Нэг товшилтоор WordPress-ийг суулгах. Зарим веб хостинг компаниуд админ хуудсандаа WordPress программыг автоматаар суулгах товчийг оруулсан байдаг. (Жишээ нь **Fantastico**-г хэлж болно) Уг товч дээр нэг товшсоноор WordPress автоматаар сууж ашиглахад бэлэн болно. Зарим вэб хостинг компани WordPress-ийн шинэ хувилбарыг Админ хуудас дээрээ тэр болгон шинэчлэн оруулаагүйгээс энэ аргаар суулгах нь зарим тохиолдолд WordPress-ийг ажиллуулах шаардлагыг хангахгүй байж болно. WordPress-ийг суулгах энэ аргын талаар номонд оруулаагүй болно.

2.2 WordPress программыг суулгах, ажиллуулах техникийн шаардлагууд

WordPress программыг компьютер дээр болон хостинг компанийн сервер дээр суулгаж ажиллуулахад дор дурдсан техникийн шаардлагуудыг хангах хэрэгтэй.

WordPress программыг компьютер дээр суулгах	WordPress программыг онлайн сервер дээр суулгах
<p>Өмнө нь вэб сайт бүтээж байгаагүй, анх удаа WordPress дээр ажиллах гэж байгаа бол энэ аргыг сонгоорой.</p> <p>Байгуулж байгаа вэб сайт интернет дээр харагдахгүй, харин вэб браузерийн тусламжтайгаар интернэт дээр хэрхэн харагдахыг үзэж болно.</p>	<p>Өмнө нь вэб сайт бүтээж байсан, WordPress-ийг ерөнхийд нь мэддэг, программыг онлайн сервер дээр суулгаж ажиллуулах зорилготой бол энэ арга танд нийцнэ.</p> <p>Байгуулж байгаа вэб сайт интернэт дээр шууд байрлах тул таны хийж байгаа вэб сайт руу интернэтэд холбоотой хүн болгон орох боломжтой.</p>
<ul style="list-style-type: none"> * Интернэт холболт * WordPress программын сүүлийн хувилбар * Вэб браузер (Mozilla Firefox) * Сервер программ WAMP (Apache сервер, MySQL Мэдээллийн сан, PHP вэб хөгжүүлэх хэл) * Notepad ++ Коде бичих программ * Зарим хэрэглээний программууд: Word, Photoshop, Illustrator 	<ul style="list-style-type: none"> * Интернэт холболт * WordPress программын сүүлийн хувилбар * Вэб браузер (Mozilla Firefox) * Вэб сайтын домайн нэр худалдаж авах * Вэб сервер болон вэб хост худалдаж авах * FTP программ * Notepad ++ Коде бичих программ * Зарим хэрэглээний программууд: Word, Photoshop, Illustrator

Сайн интернэт холболт. WordPress программын сүүлийн хувилбарыг www.wordpress.org-оос татах, программыг хостинг компанийн сервер дээр суулгахад болон бусад хэрэгцээт программ түүлүүдийг татан авахад таны компьютер интернэтэд холбогдсон байх хэрэгтэй. Интернэтийн хурд өндөр байх тусмаа сайн.

WordPress программын сүүлийн хувилбар. WordPress программын сүүлийн хувилбарыг www.wordpress.org вэбээс татан вэб сайт байгуулах компьютер дээрээ болон вэб сервер дээр суулгана. Энэ хичээлийг бэлдэх үед **WordPress программын 3.4** хувилбар гарсан байсан учир энэ хувилбарыг ашигласан болно. WordPress программ нь байнга шинэчлэгдэн өөрчлөгддөг тул та хамгийн сүүлийн хувилбарыг хэрэглэх хэрэгтэй.

Вэб браузер (Mozilla Firefox). WordPress программ нь вэб браузерийн тусламжтай ажилладаг вэб программ болно. **Internet Explorer, Mozilla Firefox, Safari** зэрэг олон вэб браузерийг интернэт хэрэглэгчид өнөөдөр хэрэглэж байна. Эдгээр браузеруудын алийг нь ч ашиглах боломжтой. WordPress программыг **Windows** үйлдлийн компьютер дээр ажиллуулахад **Mozilla Firefox** браузер илүү тохиромжтой байдаг тул уг браузерийг сонголоо.

WAMP-Windows, Apache, MySQL, PHP

Apache - Сервер программ

MySQL - Мэдээллийн сан буюу датабаз үүсгэж удирдах программ. WordPress сайтад орсон бүх агуулга уг мэдээллийн санд байрлана.

PHP нь вэб программын хэл бөгөөд уг хэл дээр WordPress бичигдсэн болно.

WAMP сервер. Компьютер дээр WordPress программыг ажиллуулах орчинг бүрдүүлэхийн тулд дараах программуудыг суулгасан байх шаардлагатай.

- ★ **PHP 5.2.4** болон түүнээс дээш хувилбар
- ★ **MySQL 5.0** болон түүнээс дээш хувилбар
- ★ **Apache** сервер

Эдгээр программуудыг тус тусад нь суулгаж WordPress –ийг ажиллуулах орчинг бий болгохоос гадна энгийн хэрэглэгч хялбархан суулгаж болох **WAMP** серверийг оронд нь суулгаж болно. **WAMP** сервер нь Windows үйлдлийн систем дээр ажилладаг **Apache, MySQL, PHP** хэмээх энэ гурван программыг нэгтгэж боловсруулсан программ болно.

Домайн нэр. Интернэт буюу сервер дээр вэб сайтаа байрлуулахад вэбийн хаяг буюу домайн нэр авах зайлшгүй шаардлагатай. Нэг домайн нэр нэг л вэб сайтад оногдоно. Түүнтэй ижил нэртэй вэб сайт байж болохгүй. Домайн нэрийг хостинг компаниуд болон домайн нэр олгодог компаниудын вэб сайтаас худалдан авна. Ойролцоогоор жилийн дундаж үнэ нь \$20-\$30 орчим байна. Домайн нэрийг хэдэн жил хэрэглэхээс хамаарч үнэ нь тогтоогдоно. Домайн нэрийг худалдаж авсан компаниас түүний хэрэглэх хугацаа дуусахаас өмнө танд хэрэглэх хугацаагаа сунгуулах тухай сануулга захираг ирнэ.

Вэб хост / Сервер. Вэб сайтаа интернэт дээр байрлуулахын тулд домайн нэр авахаас гадна вэб хостингоо сонгох хэрэгтэй. Та өөрийн сервер дээр суулгах буюу эсвэл вэб сайт байрлуулах үйлчилгээ эрхэлдэг (вэб хостинг) компанитай гэрээ хийнэ. Вэб хостинг компани бүрийн үйлчилгээний үнэ өөр өөр байна. Түүнээс гадна WordPress программын сүүлийн хувилбарыг ажиллуулахын тулд вэб хостинг компаний сервер дээр

- * [PHP](#) хувилбар 5.2.4 (болон дээш)
- * [MySQL](#) хувилбар 5.0 (болон дээш) суусан байх ёстойг анхаарна уу.

Код засварлах программ. WordPress программ нь вэб технологийн хэлүүд болох [HTML](#), [CSS](#), [Javascript](#), [PHP](#) хэлүүдийн тусламжтайгаар зохиогдсон программ юм. WordPress-ийн вэб хуудасны загварыг өөрчлөх, вэб сайтын ажиллагааг өргөжүүлэхэд WordPress-ийн файлуудыг засварлах шаардлага гарна. Тэдгээрийг өөрчлөхийн тулд сайн код засварлах программ хэрэгтэй. Код засварлахад Windows үйлдлийн компьютер дээр [Notepad](#), [Wordpad](#) программаас гадна олон программыг ашиглаж болно. Бид [Notepad++](#) гэсэн программыг код засварлахад ашиглах болно.

FTP программ. Вэб сервертэй холбогдон файлуудаа хуулах, татаж авахад хэрэглэх [File Transfer Protocol](#) хэмээх нэрлэгддэг энэ программыг компьютер дээрээ суулгах хэрэгтэй. Вэб хостинг компаниуд танд мөн [FTP IP](#) хаяг өгнө. Ихэвчлэн [IP](#) хаяг нь таны вэбийн домайн нэр байх болно. Та дараах [FTP](#) програмуудыг үнэгүй татах боломжтой. Бид [FTP](#) программаар [FileZilla](#)-г сонгосон болно.

- * [WS_FTP](#): http://www.ipswitch.com/_download/wsftphome.asp
- * [SmartFTP](#): <http://www.smartftp.com/download>
- * [FileZilla](#): <http://sourceforge.net/projects/filezilla>
- * [FTP Explorer](#): <http://www.ftpx.com>

Зарим хэрэглээний програмууд: WordPress вэб сайтад текст, зураг, дуу, видео гэх мэт олон төрлийн агуулгуудыг оруулна. Эдгээр агуулгуудын эхийг бэлтгэхэд график дизайны зарим програмуудыг компьютер дээрээ суулгасан байгаарай.

- * [Word](#) – Агуулгын текстийн эхийг бэлтгэх
- * [Photoshop](#) – [Raster](#) зураг болон фото зургийн эхийг бэлтгэх
- * [Illustrator](#) – [Vector](#) зургийн эх бэлтгэх

Дараахь программуудыг интернэтээс татаж хард диск дээрээ хадгалаарай. Үүнд:

WordPress <http://www.wordpress.org>

WAMP server <http://wampserver.com/en/>

Notepad++ <http://notepad-plus-plus.org>

Filezilla <http://filezilla-project.org>

Notepad++ болон **Filezilla** программуудыг суулгах амархан тул энэ номд оруулсангүй.


Харин **WAMP** сервер болон **WordPress** программыг хэрхэн суулгах тухай

3-р бүлэг. WordPress программыг суулгах гэсэн дараагийн өгүүллийг уншина уу.

3-р бүлэг

WordPress программыг суулгах

- 3.1 WAMP серверийг суулгах, тохиргоо хийх
- 3.2 WAMP сервер дээр WordPress программыг суулгах



3-р бүлэг. WordPress-ийг компьютер дээр суулгах

WordPress программыг компьютер дээр суулгахын тулд эхлээд сервер программыг суулгаж тохируулга хийнэ. Дараа нь уг сервер дээрээ WordPress программын сүүлийн хувилбарыг суулгана. WordPress-ийг суулгаж ажиллуулахын тулд WAMP-ийг сервер программаар сонголоо.

3.1 WAMP серверийг суулгаж тохиргоо хийх


WordPress-ийн ажиллагаа нь сервер программыг гүйцэд суулгаж, тохиргоо нь зөв хийхээс хамаарна. WAMP серверийг суулгаж тохиргоо хийх үйлдлийг дараах шатуудад хувааж болно. Үүнд:

Та компьютерт программ өмнө нь суулгаж үзээгүй бол компьютерийн техникийн мэдлэгтэй хүний тусламжтайгаар WordPress болон түүнийг ажиллуулах Сервер программыг суулгаарай.


Та өмнө нь компьютер дээр программ суулгаж байсан бол WordPress болон түүнийг ажиллуулах Сервер программыг өөрөө бие даан суулгах боломжтой.

- ★ WAMP серверийг суулгах
- ★ [Apache rewrite](#) модулыг идэвхжүүлэх
- ★ [httpd.conf](#) файлыг засах
- ★ [phpmyadmin.conf](#) файлыг засах
- ★ Мэдээллийн сан үүсгэх


3.1.1 WAMP серверийг суулгах




- ★ www.wampserver.com лүү орж [Downloads](#) хэсгээс [WAMP](#) серверийн хамгийн сүүлийн хувилбарыг компьютер дээрээ татна.




- ★ Татсан wampserver -ийн файл дээр хулганаар дарахад [Open File-Security Warning](#) диалог цонх гарч ирнэ. Цонх дээр байгаа [Run](#) товчийг дарж суулгах ажиллагааг эхлүүлнэ.




- ★ [Setup Wizard](#) диалог цонх гарч ирнэ. Цонх дээр байгаа [Next](#) товчийг дарна.




- ★ WAMP серверийг ашиглахтай холбоотой License Agreement цонх гарч ирнэ. I accept the agreement бичгийн өмнөх товчийг сонгон суулгах ажиллагааг үргэжлүүлэхийн тулд Next товчийг дарна.




- ★ Гарч ирэх Select Destination Location цонх дээр WAMP серверийн файлуудыг хуулах C:\wamp хавтасыг үүсгэсэн байна. Next товчийг дарна.




- ★ **Select Additional Tasks** цонх дээр **WAMP** –ийг ажиллуулахад хэрэглэх хоёр товчийг сонгоно. Компьютерийн дэлгэц дээр **WAMP** серверийг шууд ажиллуулах **shortcut** буюу зурган товч үүсгэх **Create a Desktop Icon**-г идэвхжүүлээ.




- ★ **Next** товчийг дарахад **Ready to Install** цонх гарч ирнэ. **Install** товчийг дарж **WAMP** серверийг суулгах ажиллагааг үргэлжлүүлнэ.




- ★ Дэлгэц дээр **WAMP** серверийг суулгах үйлдэл хийгдэж байгааг харуулна. Компьютерийн хүчин чадлаас суулгах хугацаа хамаарна.



- ★ **WAMP** серверийг ажиллуулах браузер программаар **Firefox**-ыг сонгох эсэхийг асуусан цонх гарч ирэхэд **Yes** товчийг дарна.




- * Бид компьютер дээр WAMP-ийг суулгаж байгаа тул **PHP Mail Parameters** цонх дээр мэдээллүүдийг заавал өөрчлөх шаардлагагүй. **Next** товчийг дарна.



- * Хамгийн сүүлд гарч ирэх энэ цонх дээр **WAMP**-ыг шууд ажиллуулахыг хүсвэл **Launch Wampserver 2 now** бичгийн өмнөх дөрвөлжинг сонгоод **Finish** товчийг дарна. Хэрэв шууд ажиллуулахыг хүсэхгүй бол дөрвөлжинг сонголгүй орхино. Энэ тохиолдолд дараа нь **WAMP** серверийг ажиллуулахдаа дэлгэц дээр гарч ирсэн түүний зурган товч дээр дарна.


WAMP серверийг ажиллуулахад компьютерийн дэлгэцийн баруун доод тал дээр түүний зурган товч гарч ирнэ. WAMP серверийг гүйцэд ажиллуулахыг тулд зурган товч дээр дарж гарч ирэх цэсээс Stop service товчийг дараад, түр хүлээж байгаад Start Service товчийг дарна. Stop service-товчийг дарахад WAMP серверийн товч улаан өнгөтэй болно. Start service товчийг дарахад эхлээд шар, дараа нь ногооноор солигдож сервер бүрэн ажиллаж эхэлнэ.



WordPress программыг ажиллуулахад WAMP сервер бүрэн ажиллаж байх ёстой. WAMP серверийг бүрэн ажиллуулахын тулд зарим тохиргоог хийх хэрэгтэй болдог. Үүнд: Apache rewrite_module-ийг идэвхжүүлээгүй бол түүнийг идэвхтэй болгож, шаардлагатай бол httpd.conf болон phpadmin.conf зэрэг файлуудад бага зэргийн засвар хийнэ.


3.1.2 Apache rewrite_module-ийг ажиллуулах

- ★ Цонхны баруун доод талын бар дээр байгаа WAMP серверийн товч дээр дарж Apache < Apache Module товчийг дарж гарч ирсэн модулуудаас rewrite_module гэсэн бичгийн дарж идэвхжүүлнэ.
- ★ WAMP серверийг Restart хийвэл сая Apache дээр сонгосон rewrite_module сонголт хүчинтэй болно.



3.1.3 httpd.conf файлд засвар хийх

- ★ httpd.conf файлд засвар хийнэ. Цонхны баруун доод талын бар дээрээс WAMP серверийн товч дээр дараад Apache < httpd.conf-ийг дарж файлыг NotePad дээр нээнэ.
- ★ Файлд байгаа текстээс Onlineoffline tag - don't remove мөрний дор байгаа



```
Order Deny,Allow
Deny from all
Allow from 127.0.0.1
```

ХЭСГИЙГ

```
Order Allow,Deny
Allow from all
Allow from 127.0.0.1
```

болгож өөрчлөөд хадгална.

- ★ WAMP серверээ дахиад Restart хийнэ.

```
# onlineoffline tag - don't remove
Order Deny,Allow
Deny from all
Allow from 127.0.0.1

# onlineoffline tag - don't remove
Order Allow,Deny
Allow from all
Allow from 127.0.0.1
```

3.1.4 phpmyadmin.conf файлыг засах

- * C:\wamp\alias хавтас дотор байгаа `phpmyadmin.conf` файлыг нээнэ. Файл дээр байгаа

```
<Directory "c:/wamp/apps/phpmyadmin3.4.9/">
    Options Indexes FollowSymLinks MultiViews
    AllowOverride all
    Order Deny,Allow
    Deny from all
    Allow from 127.0.0.1
</Directory>
```

```
<Directory "c:/wamp/apps/phpmyadmin3.4.9/">
    Options Indexes FollowSymLinks MultiViews
    AllowOverride all
    Order Allow,Deny
    Allow from all
    Allow from 127.0.0.1
</Directory>
```

гэдгийг

```
<Directory "c:/wamp/apps/phpmyadmin3.4.9/">
    Options Indexes FollowSymLinks MultiViews
    AllowOverride all
    Order Allow,Deny
    Allow from all
    Allow from 127.0.0.1
</Directory>
```

гэж засаж бичээд хадгална.

- * WAMP серверээ **Restart** хийгээд **Localhost** товч дээр дарвал WAMP серверийн **Server Configuration** хуудас гарч ирнэ. Өөрөөр хэлбэл WAMP серверийг ашиглахад бэлэн боллоо гэсэн үг.

The screenshot shows the WampServer interface. At the top left is the WampServer logo. Below it, the text 'WampServer' is displayed. On the right side, there are links for 'Version 2.2' and 'Version Française'. The main section is titled 'Server Configuration' and contains the following information:

- Apache Version : 2.2.21
- PHP Version : 5.3.10
- Loaded Extensions : A grid of 32 extensions, each with a star icon, including Core, ctype, ftp, mcrypt, Reflection, tokenizer, dom, wddx, apache2handler, mysqli, xdebug, bcmath, date, hash, SPL, session, zip, PDO, xml, mbstring, pdo_mysql, calendar, ereg, iconv, odbc, standard, zlib, Phar, xmlreader, gd, pdo_sqlite, com_dotnet, filter, json, pcre, mysqlnd, libxml, SimpleXML, xmlwriter, mysql, and mhash.
- MySQL Version : 5.5.20

At the bottom, there is a 'Tools' section with icons and links for 'phpinfo()' and 'phpmyadmin'.


3.1.5 Мэдээллийн сан үүсгэх

WordPress вэб сайтад оруулсан агуулгууд, вэб сайтын тохиргооны мэдээллүүд нь мэдээллийн санд байрлана. Мэдээллийн санг үүсгээгүй тохиолдолд WordPress-ийг ажиллуулж бас чадахгүй.

Хостинг компаний вэб сервер дээр WordPress-ийг суулгаж байгаа бол танд шинээр мэдээллийн сан үүсгэх шаардлага байхгүй. Танд хостинг компани веб сайтын агуулгаа хадгалах мэдээллийн санг үүсгэж өгнө. Та энэ мэдээллийн санд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгээ хостинг компаниас лавлах хэрэгтэй.

Харин та компьютер дээр WordPress вэб сайтаа бүтээж байгаа бол мэдээллийн санг WAMP серверийг ажиллуулж үүсгэнэ. Мэдээллийн санг үүсгэхийн тулд:

- * [Server Configuration](#) хуудасны [Tools](#) хэсэгт байгаа [phpMyAdmin](#) холбоос дээр дарах буюу эсвэл WAMP серверийн дүрс дээр дараад гарч ирэх цэснээс [phpMyAdmin](#) -ыг сонгон [phpMyAdmin](#) хуудсыг гаргаж ирнэ.
- * Энэ хуудас дээрээс хамгийн эхний товч болох [Databases](#)-ийг дарж [phpMyAdmin-ий Databases](#) хуудсыг гаргаж ирнэ.
- * Гарч ирсэн хуудас дээрх [Create new database](#) бичгийн доор байгаа нүдэнд шинээр үүсгэх мэдээллийн сангийн нэрийг оруулж [Create](#) товчийг дарна.
- * [PhpMyAdmin](#) хуудасны хажуу баганад байгаа нэрсүүд дээр шинээр үүссэн мэдээллийн сангийн нэр нэмэгдэж гарч ирнэ.



Өөрөөр хэлбэл WordPress вэб сайтад орох агуулгууд болон вэб сайтын тохиргоо, мэдээллүүдийг хадгалах мэдээллийн сан бэлэн боллоо гэсэн үг.

Дараагийн алхам бол WordPress программын сүүлийн хувилбарыг татаж WAMP сервер дээр суулгах ажиллагаа болно.

3.2 WAMP сервер дээр WordPress-ийг суулгах

WAMP сервер дээр WordPress-ийг суулгах ажиллагаа нь:

- ★ Wordpress-ын хувилбарыг татаж www хавтсанд зөөх
- ★ [wp-config-sample.php](#) файлд засвар хийж, нэрийг нь өөрчлөх
- ★ WordPress-ийг монгол хэл дээр ажиллуулах [mn_MN.mo](#) файлыг оруулах
- ★ WordPress-ийг суулгах гэсэн дарааллаар хийгдэнэ.

Компьютер дээрээ WAMP серверийг суулгаж, түүнийг бүрэн ажиллуулахын тулд зарим файлд засвар хийж, сервер дээр мэдээллийн сан үүсгэсэн бол таны компьютер одоо вэб сервер компьютерийн үүрэг гүйцэтгэх боломжтой боллоо гэсэн үг. Өөрөөр хэлбэл уг сервер дээр вэб сайт байрлуулж болно.

WAMP сервер дээр WordPress программыг суулгах энэ үйлдэл нь WordPress программыг хостинг компаний сервер дээр суулгахтай яг адилхан үйлдэл болно.

3.2.1 WordPress программын хувилбарыг татаж www хавтсанд зөөх

- ★ WordPress программ нь [.zip](#) өргөтгөлтэй архивын файл байдлаар www.wordpress.org дээр тавигдсан байна. www.wordpress.org луу орж WordPress программын хамгийн сүүлийн хувилбарыг компьютерийн хард диск дээрээ татна.
- ★ WordPress-ийн архив файлыг задлахад [wordpress](#) нэртэй хавтас дотор [wp](#) гэсэн хоёр үсгээр эхэлсэн файл болон хавтасуудад задрагдана.
- ★ WordPress хавтас дотор байгаа бүх файл болон хавтасуудыг [WAMP server](#) дотор байгаа www хавтсанд зөөж оруулна.
- ★ Зөвхөөс өмнө www хавтсанд байгаа [index.php](#) файлыг устгана.

3.2.2 [wp-config-sample.php](#) файлд засвар хийж, нэрийг нь өөрчлөх

www хавтсанд зөөсөн файлууд дотроос [wp-config-sample](#) файлыг [Notepad++](#) программ дээр онгойлгож зарим мэдээллүүдийг шинээр оруулж хадгална. Үүнд:

- ★ [wp-config-sample.php](#) файлд мэдээллийн сан буюу датабазын нэр, хэрэглэгчийн нэр, нууц үгийг дараахь мөрүүдэд оруулна.

Сануулах нь:

Хэрэв та хостинг компанийн вэб сервер дээр WordPress-ийг суулгаж байвал танд `DB_NAME`, `DB_USER`, `DB_PASSWORD` дээр бичих мэдээллийг вэб хост компани өгнө.

```
define('DB_NAME', 'putyourdbnamehere'); // Датабаз нэр
define('DB_USER', 'usernamehere'); // MySQL хэрэглэгчийн нэр
define('DB_PASSWORD', 'yourpasswordhere'); // Нууц үг
define('DB_HOST', 'localhost'); // 99% энэ мэдээллийг өөрчлөх шаардлагагүй
```

Мэдээллүүдийг оруулбал:

```
define('DB_NAME', 'byamba');
define('DB_USER', 'root');
define('DB_PASSWORD', ''); // Компьютер дээр программаа суулгаж байгаа тул нууц үгийг түр орхич.
define('DB_HOST', 'localhost'); // 99% энэ мэдээллийг өөрчлөх шаардлагагүй
```

- ★ `wp-config-sample.php` (`wp-config.php`) документайн **Authentication Unique Keys** буюу багц нууц түлхүүр үгс хэсэгт шинэ нууц түлхүүр үгсийг сольж хийнэ.

```
define('AUTH_KEY', '');
define('SECURE_AUTH_KEY', '');
define('LOGGED_IN_KEY', '');
define('NONCE_KEY', '');
```

Ингэхийн тулд <https://api.wordpress.org/secret-key/1.1/> холбоос руу орж браузер дээр гарч ирэх түлхүүр үгсийг хуулж `config` файл дээр сольж тавина

```
define('AUTH_KEY', 'Psm059sFXB*XDwQ!<uj)h=vv#Kle`)dBE0M:0oBzj`V(qd0.nP2|BT~T$a(;6-&!');
define('SECURE_AUTH_KEY', 'o>p3K{TD.tJoM74.Oy5?B@=dF_lcm1B6jm6DgXn1J#Z4K,M>E;[ +,22O?Lnarb');
define('LOGGED_IN_KEY', 'c}gR{389F*IG@/V+hg1*H+9i_^HaF;$q(S[5Er[:DVOUjmS@ (20E~t0-C*II');
define('NONCE_KEY', 'gz2D:n52|5wRvh)es:800|O ufZL@C|G.-w/H-E*}K:ygp4wI*.QHO-mUV_PR|6M');
```

Ингэж түлхүүр үгсийг оруулах нь сайтыг муу хүмүүсээс хамгаалахад бага ч гэсэн тустай.

- ★ WordPress вэб сайтыг өөрийн хэл дээр удирдах боломжтой. Монгол хэлний файл нь `mn_MN.mo` гэсэн нэртэй байна. `wp-config-sample.php` (`wp-config.php`) документад байгаа `define('WPLANG', 'mn_MN');` кодед `'mn_MN'` хэмээн бичнэ. Мөн монгол хэлний файлыг WordPress программын `wp-content` хавтаст `languages` хавтас шинээр үүсгэн дотор нь хуулж оруулснаар вэб сайтыг монгол хэл дээр удирдахад бэлэн болно. Хэлний файлуудыг хэрхэн хуулах тухай тусад нь уншина уу.
- ★ Эцэст нь `wp-config-sample.php` файлаа `wp-config.php` болгон хадгална.

3.2.3 WordPress-ийг монгол хэл дээр ажиллуулах mn_MN.mo файлыг оруулах

WordPress 3.4 хувилбарын хэлний файлыг WordPress программын `wp-content` хавтас дотор `languages` хавтас шинээр үүсгэн дотор нь хуулж ашиглахад бэлэн болно. Үүнээс гадна тухайн хэрэглэж байгаа вэб загварын хэлний файлыг уг вэб загварын хавтас дотор мөн `languages` хавтас шинээр үүсгэн хуулна. Үүнд:

- ★ `/wp-content/languages/mn_MN.mo` – WordPress-ийг монгол хэл дээр ажиллуулах гол файл
- ★ `/wp-content/languages/admin-mn_MN.mo` – WordPress-ийг монгол хэл дээр удирдах админ вэб сайтын хэлний файл
- ★ `/wp-content/languages/continents-cities-mn_MN.mo` Цагийн бүсэд хамаарагдаж байгаа хот, улсын нэрүүдийн монгол нэрийн файл
- ★ `/wp-content/languages/ms-mn_MN.mo` - WordPress сайтыг сүлжээ болгон өргөжүүлэхэд хэрэглэх Сүлжээний Админы монгол хэлний файл
- ★ `/wp-content/themes/twentyten/languages/mn_MN.mo` - `TwentyTen` вэбийн загварын монгол хэлний файл
- ★ `/wp-content/themes/twentyeleven/languages/mn_MN.mo` – `TwentyEleven` вэбийн загварын монгол хэлний файл

WordPress-ийг монгол хэл дээр гүйцэт орчуулж хараахан дуусаагүй бөгөөд хэрэв эдгээр хэлний файлыг ашигласан ч вэб хуудас дээр зарим үгнүүд англиар гарч ирж болно. WordPress-ийн хэлний файлуудад засвар хийн үгсийг монгол болгон гаргаж болно. Одоогоор орчуулагдсан хэлний файлыг `www.amarnet.org` вэб сайт руу орж татан авч болно.

3.2.4 WordPress-ийг суулгах

Дэлгэцийн доор байгаа `Wamp` серверийг идэвхжүүлж хулганаараа хамгийн дээр байгаа `Localhost` товчийг дарвал WordPress программыг суулгах вэб хуудас гарч ирнэ.

- ★ Хуудас дээр вэб сайтын нэр(`Site Title`), хэрэглэгчийн нэр(`User Name`), нууц үгээ(`Password, twice`) оруулна. Нууц үг оруулах нүдэнд хэр нууцлалтай үг оруулсанг түүний дор гарах `Чанар илэрхийлэгч` (`Strength indicator`) зааж өгнө. `e-mail` хаягаа заавал оруулах шаардлагатай. Хэрэв оруулахгүй бол WordPress программын суулгах ажиллагаа төгсгөл болж чадахгүй.
- ★ Хамгийн сүүлд вэб сайтыг хайлтын систем дээр нээлттэй байх үгүйг сонгоно. Бид өөрийн хэрэглэж байгаа компьютер дээр буюу интернэтийн орчинд ажиллахгүй тул энэ `Хайлтын технологи`



Тавтай морилно уу

Таныг алдарт Wordpress-ийг таван минутад суулгах ажиллагаанд урьж байна! Магадгүй та чөлөөт цагаараа ReadMe documentation баримтыг аажуухан гүйлгэн харахыг хүсэж байж болох юм. Эс бөгөөс дор байгаа хэсэгт мэдээллүүдийг оруулснаар дэлхийд хамгийн ихээр цар хүрээгээ тэлж буй хүчирхэг хэвлэн нийтлэх системийг ашиглах таны гараа эхлэх болно.

Мэдээлэл хэрэгтэй

Дараахь мэдээллийг бөглөнө үү. Санаа зоволтгүй, эдгээр тохиргоог та дараа өөрчлөх боломжтой.

Сайтын гарчиг

Хэрэглэгчийн нэр
Username can have only alphanumeric characters, spaces, underscores, hyphens, periods and the @ symbol.

Нууц үг, хоёр удаа
Хэрвээ хоосон орхих юм бол нууц үгийг автоматаар танд үүсгэж өгнө.

Сануулга: Нууц үг хамгийн багадаа долоон тэмдэгтийн урттай байх хэрэгтэй. Нууцлал сайтай үг үүсгэхийн тулд том жижиг үсэг, тоо болон ! " ? \$ % ^ &) мэтгйн тэмдэгтийг ашиглана уу.

Таны и-мэйл

Цааш үргэлжлүүлэхийн өмнө и-мэйл хаягаа давхар шалгана уу.

Нууцлал Хайлтын технологи сайтыг индекслэхийг зөвшөөрөх.



Амжилттай!

WordPress-г суулгасан. Та илүү олон алхам хүлээж байсан уу?

Хэрэглэгчийн нэр byamba

Нууц үг Таны олонхосон нууц үг

сайтыг индекслэхийг зөвшөөрөх бичгийн өмнөх дөрвөлжинг сонгох шаардлагагүй.


- ★ WordPress-ийг суулгах (**Install WordPress**) товчийг дарахад WordPress-ийг амжилттай суулгасан тухай доорхи диалог цонх гарч ирнэ.
- ★ **Нэвтрэх (Log In)** товч дээр дарахад Админ вэб сайт руу нэвтрэх цонх гарч ирснээр WordPress-ийг суулгах ажил дуусна.
- ★ Нэвтрэх цонхонд мэдээллүүдээ оруулад **Нэвтрэх (Log In)** товчийг дарж WordPress вэб сайтын Админ вэб рүү орно.

4-р бүлэг

Админ болон WordPress вэб сайт

4.1 WordPress вэб сайт, түүний хуудасны ерөнхий бүтэц

4.2 Админ вэб сайт



4-р бүлэг. Админ болон WordPress вэб сайт

WordPress программыг суулгаснаар та [Админ сайт](#), [WordPress сайт](#) гэсэн хоёр өөр вэб сайт дээр ажиллах болно.

Админ вэб сайт(Back End)

Админ систем буюу Админ вэб сайт дээр шинээр агуулга оруулах, засах, устгах, вэб дизайны загварыг өөрчлөх, плагин суулгах гэх мэтээр вэб сайтыг удирдах бүхий л үйлдлийг хийнэ. Админ сайт дээр вэб сайтын админ, зохиолч, болон бусад бүртгүүлсэн хэрэглэгчид ажиллах боломжтой. Хэрэглэгч бүр өөрийн хэрэглэгчийн нэр, нууц үгээ ашиглан админ вэб сайт руу нэвтрэн орно.

WordPress вэб сайт (Front End)

Админ вэб сайт дээр хийсэн ажлын үр дүнд интернэт хэрэглэгч унших вэб сайт байгуулагдана. WordPress программыг суулгаж анх ажиллуулахад дэлгэц дээр энгийн бүтэцтэй блог буюу вэб сайтын нүүр хуудас гарч ирнэ. Энэ вэб сайтыг WordPress вэб сайт гэнэ. Өөрөөр хэлбэл WordPress программ нь энгийн бүтэцтэй вэб сайт шууд байгуулж өгнө. Админ вэб сайт руу орж энэ вэбийн бүтэц дизайныг өөрчлөн өөрсдийн брэнд сайт болгон сайжруулна.

4.1 WordPress вэб сайт, түүний хуудасны ерөнхий бүтэц (Front End)

WordPress программыг ашиглан хийх вэб сайтын хуудасны бүтцийг ерөнхийд нь [толгой](#), [хажуу багана](#), [агуулгын хэсэг](#), [хөл](#) гэсэн хэсгүүдэд хувааж болно. WordPress вэб сайтын хуудасны ерөнхий бүтцийг [\[Зураг-4.1\]](#) зурагт харууллаа.

[Толгойн хэсэгт](#) вэб хуудасны нэр, лого, уриа үг, вэб сайтын бусад хуудас болон бичлэг рүү орох гол цэс, толгойн зураг зэрэг байрлана. [Хажуу багана](#) буюу нэмэлт мэдээлэл гарч ирэх хэсэгт нэвтрэх хэсэг рүү орох холбоос, хайлт хийх, нэмэлт цэснүүд болон зар сурталчилгаа зэрэг виджет ашиглан гарч ирэх элементүүд байрлана. [Агуулга хэсэг нь](#) вэб хуудасны хамгийн гол хэсэг бөгөөд бичлэг болон хуудасны агуулгуудыг гарган ирж уншина. Мөн энэ хэсэгт уншигчдын оруулсан сэтгэгдлүүд байрлана. [Хөлийн](#) хэсэгт ихэвчлэн

ТОЛГОЙ

- * вэб сайтын нэр
- * лого
- * вэб сайтын уриа үг
- * толгойн зураг
- * сайтын навигацийн цэсүүд байрлана.

[Зураг-4.1]
WordPress вэб хуудасны
ерөнхий бүтэц, хэсэг бүрд
байрлах элементүүд

АГУУЛГА

Вэб сайтын мэдээлэл түгээх
үндсэн талбар.

Энэ хэсэгт сайтад оруулсан
бичлэг болон хуудасны
агуулгууд, уншигчдын оруулсан
сэтгэгдлүүд гарч ирнэ.

ХАЖУУ БАГАНА

Админ вэб рүү
нэвтрэн орох холбоос,
хайлт хийх талбар,
туслах цэсүүд,
бусад сайтууд руу
орох холбоосууд,
зар сурталчилгааны
баннер гэх мэт виджет
ашиглан гарч ирэх
элементүүд байрлана.

ХӨЛИЙН ХЭСЭГ

Вэб сайтын цэсүүд, компанийн мэдээлэл,
зохиогчийн эрхтэй холбоотой мэдээллүүдийг
ерөнхийд нь тавина. Өөр нэмэлт мэдээлэл ч
тавьж болно.


вэб сайтыг ашиглах журам, зохиогчийн эрхийн мэдээлэл байхаас гадна бусад
нэмэгдэл мэдээлэлүүдийг байрлуулж болно.

[Зураг-4.2]
WordPress программын
3.4 хувилбарт хамт ирсэн
Хоёрмынга арван нэг
(Twenty Eleven) нэртэй
вэб загварыг ашигласан
энгийн бүтэцтэй вэб
сайтын нүүр хуудас

Толгой хэсэг

Агуулгын хэсэг

Хөлийн хэсэг



WordPress программын 3.4 хувилбарыг суулгаад ажиллуулахад [Хоёрмынга арваннэг \(Twenty Eleven\)](#) нэртэй вэбийн загварыг ашигласан энгийн бүтэцтэй вэб сайтын нүүр хуудас гарч ирнэ. Энэ WordPress вэб сайтын нүүр хуудасны зургийг [\[Зураг-4.2\]](#)-т харууллаа.

[Толгойн хэсэгт](#) WordPress-ыг суулгах үед оруулсан вэб хуудасны нэр, таг мөр - [Өөр нэгэн WordPress сайт \(Just another WordPress site\)](#) гэсэн бичиг, толгойн зураг, мөн [Нүүр](#), [Sample Page](#) гэсэн загвар хоёр цэсийн нэр гарч ирсэн байна. [Хажуу баганад](#) [Хайлт\(Search\)](#), [Шинэ бичлэгүүд\(Recent Posts\)](#), [Шинэ сэтгэгдлүүд\(Recent Comments\)](#), [Архивууд\(Archives\)](#), [Ангилал\(Categories\)](#), [Мета\(Meta\)](#) зэрэг виджет



Толгой хэсэг

[Зураг-4.3] WordPress программыг ашиглан бүтээсэн Оногдохуйн тавилан вэб сайтын нүүр хуудас

Миний аав Намхай овогтой Элзийбат нь Монголын хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж ирсэн, олон сайхан уран бүтээл туурвисан зохиолч, сэтгүүлч, эгэл жирийн сэхээтэн, геологич мэргэжилтэй хүндтэй хүн юм. Аавынхаа “Оногдохуйн тавилан”, “Чамтай танилцсан өдөр”, “Үгийн ачаа”, “Шүлгэн эрих буюу 108 шившлэг” зэрэг номнуудад орсон уншихад ухаарал өгөх, сургамж болох, урам оруулах, уяран хайлуулах шүлэг, богино өгүүллэг, бодрол, уянгын зураглалуудыг түүвэрлэн Оногдохуйн тавилан нэртэй вэб сайтыг WordPress программыг ашиглан бүтээсэн юм.

ашиглан үүсэх нэмэлт мэдээллүүдийг гаргасан байна. Агуулга хэсэгт WordPress программын *Hello world!* загвар бичлэгийг харахаас гадна Хөлийн хэсэгт WordPress ажиллуулж байна (*Proudly powered by WordPress*) гэсэн бичгийг оруулсан байна.

Энэ вэб сайтын дизайны загварыг өөрчлөн дотор нь байгаа загвар агуулгын оронд вэб сайтад орох жинхэнэ агуулгаа оруулан вэб сайтаа байгуулж эхлэнэ. WordPress программыг ашиглан бүтээсэн Оногдохуйн тавилан вэб сайтын нүүр хуудсыг [Зураг-4.3] дээр үзүүллээ.

4.2 Админ вэб сайт (Back End)

Вэбсайтад шинээр агуулга нэмэх, вэб дизайны загварыг өөрчлөх, шинээр ажиллагааг нь өргөжүүлэх зэрэг бүхий л үйлдлийг Админ вэб дээр хийнэ. Иймээс вэб сайтад өөрчлөлт хийхийн тулд хамгийн түрүүнд Админ вэб сайт руу орох хэрэгтэй.

4.2.1 Админ вэб сайт руу орох

МЕТА
■ Нэвтрэх
■ Entries RSS
■ Comments RSS
■ WordPress.org

Админ вэб сайт руу орохын тулд :

Вэб сайтыг нүүр хуудсанд байрлах [Нэвтрэх холбоос \(Log-in\)](#) дээр дарна.

`http://www.домайннэр.com/wp-login.php`

Эсвэл вэб браузер дээрхи вэбийн хаяг бичих нүдэнд [домайн нэрийн ард зураас wp-login.php](#) гэж бичээд **ENTER** дарахад [Нэвтрэх цонх](#) гарч ирнэ.

Бид компьютер дээр WAMP серверийг суулган туршилтын WordPress вэб хийж байгаа учир админ вэб рүү орохын тулд эхлээд WAMP серверээ ажиллуулна. Тэгээд браузер дээрхи вэбийн хаяг бичих нүдэнд

`localhost/wp-login.php`

гэж бичээд ENTER дарна.

[Нэвтрэх цонх](#) дээр WordPress-ийг суулгах үед оруулсан [Хэрэглэгчийн нэр \(User name\)](#) болон [Нууц үг \(Password\)](#)- ээ бичээд [Нэвтрэх товч \(log In\)](#)-ийг дарж админ сайт лүү орно.


Хэрэглэгчийн нэр болон нууц үгэнд хэрэглэсэн том болон жижиг үсгийн тэмдэгтийг зөрүүлж бичвэл дэлгэц дээр хэрэглэгчийн нэр/нууц үгээ буруу оруулсан талаар сануулга бичиг гарч ирэх бөгөөд та админ вэб сайт руу орж чадахгүй. Иймээс нэвтрэх мэдээллээ зөв оруулах хэрэгтэй.

[Намайг сана \(Remember Me\)](#) бичгийн өмнөх дөрвөлжинг сонговол хэрэглэгчийн нэр, нууц үгийг систем хадгална. Админ вэб сайтаас гараад дахин ороход нэвтрэх цонх дээр хэрэглэгчийн нэр, нууц үг шууд гарч ирнэ.

Нууц үгээ мартсан тохиолдолд [Нууц үгээ мартсан уу \(Lost your password\)](#) товчийг дарж гарч ирэх цонхон дээр емейл хаягаа бичиж [Шинэ нууц үг авах \(Get New Password\)](#) товчийг дарна. Та емейл хаягаараа шинэ мессеж хүлээн авна.

4.2.2 Админ вэб сайтын хуудасны ерөнхий бүтэц

Админ вэб сайт руу нэвтрэн орох бүр дэлгэц дээр хамгийн түрүүнд [Самбар \(Dashboard\)](#) хуудас гарч ирнэ. Энэ хуудсыг Админ вэб сайтын нүүр хуудас гэж хэлж болно. WordPress программын админ вэб хуудасны ерөнхий бүтцийг [Зураг-4.4] зурагт харууллаа.



Админ вэб сайтын хуудасны бүтцийг [Админ бар](#), [Админ цэс](#), [Вэбийг ажиллуулах гол хэсэг](#), [төгсгөл](#) хэсгүүдэд хувааж болно. [Админ бар](#), [Админ цэс](#), [Төгсгөл](#) хэсгүүд нь админ вэбийн хуудас болгон дээр гарч ирнэ.

[Зураг-4.4] WordPress программын Админ вэб хуудасны ерөнхий бүтэц

Харин WordPress вэб сайтыг ажиллуулах, удирдах хэсэгт гарч ирэх виджетүүд нь Админ цэсийг дараад гарч ирэх хуудсаас хамаарч өөр өөр байна.

4.2.3 Админ бар



Толгойн хэсэгт [админ бар \(Admin bar\)](#) байрлана. Админ барын баруун доод хэсэгт [Дэлгэцийн сонголт \(Screen Options\)](#), [Тусламж товч \(Help\)](#)-нууд байрлана.


WordPress 3.1 хувилбараас эхлэн шинээр Админ барыг хэрэглэх болсон. WordPress программыг анх суулгаад хэрэглэгчийн нэр, нууц үгээ хийн нэвтрэн ороход WordPress вэб болон админ вэб хуудасны толгойн хэсэгт админ бар гарч ирнэ. Хэрэв нэвтрэн ороогүй бол админ бар вэб хуудасны дээр гарч ирэхгүй. Өөрөөр хэлбэл вэб сайтад зочилсон жирийн хэрэглэгчид админ бар харагдахгүй.

WordPress 3.3.1 хувилбараас Админ барыг админ вэб хуудасны толгойн хэсэгт байнга гарч байхаар зохиосон. Админ бар дээр дараах цэсүүд байрлана.


WordPress лого. WordPress.org сайт түүний Co-dex хэсэг болон WordPress форум сайт руу орох холбоосууд байрлана.



Вэбийн нэр. Админ вэб сайт дээр байвал WordPress вэб сайт руу орох холбоос, WordPress вэб сайт дээр байвал админ вэб сайтын самбар, загварыг өөрчлөх, виджет, цэс үүсгэх хуудас, вэб сайтны толгой зураг



засах, дэвсгэр өнгө өөрчлөх хуудсууд руу орох холбоосууд гарч ирнэ.





Вэбд орсон сэтгэгдлүүд рүү орох холбоос



Вэбд орсон сэтгэгдлүүд рүү орох холбоос

+Шинэ. Энэ цэс дээр шинээр бичлэг, хуудас үүсгэх, медиа файл оруулах, холбоос үүсгэх, хэрэглэгч нэмэх хуудсуудыг гаргаж ирэх холбоосууд байрлана



Юу байна (Howdo) холбоос.

Энэ холбоос дээр дарахад **Профайл засах (Edit My Profile)**, болон админ вэб сайтаас **Гарах (Log Out)** холбоосууд гарч ирнэ.

Дэлгэцийн тохируулга, Тусламж товч

Дэлгэцийн сонголт ▼ Тусламж ▼

Админ барын баруун доод хэсэгт [Дэлгэцийн сонголт\(Screen Options\)](#) болон [Тусламж\(Help\)](#) товчууд зэрэгцэн байрлана

[Дэлгэцийн сонголт\(Screen Options\)](#) товчийг дарахад нэмэлт панел цонх нээгдэнэ. Энэ панел дээр админ вэб сайтын ажлын гол талбар дээр байрлах виджетүүдийн нэр болон бусад элементүүдийн нэр гарч ирнэ. Панел дээр гарч ирсэн виджетийн нэр болон элементийн нэрийн өмнөх дөрвөлжинг сонгож уг виджет болон элементийг дэлгэц дээр буюу ажлын гол хэсэг дээр гаргаж ирнэ. Өөрөөр хэлбэл [Дэлгэцийн сонголт\(Screen Options\)](#) панелын тусламжтайгаар зөвхөн хэрэглэх виджетүүдээ дэлгэц дээр гаргаад, ашиглахгүй бусад виджетүүдийг түр зуур харагдахгүй болгоно.

Жишээ нь: [Самбар\(Dashboard\)](#) хуудас дээр ажиллаж байх үед [Шинэ сэтгэгдлүүд\(Recent Comments\)](#) болон [Ирсэн холбоосууд\(Incoming Links\)](#) виджетийг ашиглах шаардлага байхгүй бол нэрийн өмнөх дөрвөлжинд байгаа чагтыг арилгаж виджетүүдийг дэлгэц дээрээс алга болгоно. Дэлгэцийн зохиомж хэсэг дээр ашиглах виджетүүдийг нэг, хоёр, гурван эгнээнд байрлуулах сонголтыг хийнэ.


Дэлгэц дээр харуулах

Яг одоо Шинэ сэтгэгдэл Ирсэн холбоосууд Плагин ШуурхайХэвлэл Шинэ ноорог

WordPress Блог WordPress-ийн бусад мэдээ Тавтай морилно уу

Дэлгэцийн зохиомж


Баганын тоо: 1 2

 **Самбар** Дэлгэцийн сонголт ▲

Яг одоо	ШуурхайХэвлэл
Плагин	Шинэ ноорог
WordPress-ийн бусад мэдээ	WordPress Блог

[Тусламж товч\(Help\)](#)-ийг дарж WordPress-ийг ажиллуулах заавар мэдээлэл гаргаж ирнэ.

4.2.4 Админ цэс



Админ вэбийн баруун хэсэгт Админ цэс байрлана. Админ цэс WordPress вэб сайтад агуулга оруулах, шинээр плагин, вэб загвар суулгах, навигацийн цэс үүсгэх, тохируулга хийх зэрэг бүх л ажлыг удирдах хуудсуудыг гаргаж ирнэ.

Админ цэсийг [Самбар](#), [Агуулгын](#) болон [Тохиргооны](#) цэсүүд гэсэн гурван гол бүлэгт хувааж болно. WordPress программын Админы цэс, дэд цэсүүдийн бүтцийг харуулсан зургийг 39-р хуудас дээр харууллаа.

Самбар цэсүүд: Самбар нүүр хуудас(*Home*), Шинэчлэл (*Update*) гэсэн хоёр цэсээс тогтож байна. Админ вэб сайт руу орох болгонд Самбар нүүр хуудас(*Home*) хамгийн түрүүн гарч ирнэ.


Агуулгын цэсүүд: Бичлэг(*Posts*), Медиа(*Media*), Холбоос (*Links*), Хуудас(*Pages*), Сэтгэгдэл(*Comments*) цэсүүд орно. Агуулгын цэсүүд нь WordPress вэб сайтад шинээр агуулга оруулах, засах, устгах ажлуудыг хийнэ.

Тохиргооны цэсүүд: Үзэмж(*Appearance*), Плагин (*Plug-ins*), Хэрэглэгч(*Users*), Багаж(*Tools*), Тохиргоо(*Settings*) гэсэн цэсүүдээс тогтоно. Тохиргооны цэсүүд нь вэб сайтын дизайныг өөрчлөх, ажиллахад шаардлагатай тохиргоонуудыг хийх болон нэмэгдэл програмуудыг суулгаж ажиллуулна.

Админ цэсийг сонгох, дэлгэх, хураангуйлах

Админ хуудас дээр ажиллах үед админ цэсийг дэлгэж, хураагуйлж болохоос гадна аль нэг цэс рүү орохын тулд хэд хэдэн аргаар орж болно.

Админ цэсийн дор байгаа [Цэс хураангуйлах](#) (*Collapse Menu*) товчийг дарахад цэсүүдийн нэрс алга болж зурган хэлбэрт орно. [Цэс хураангуйлах](#) (*Collapse Menu*) зурган товч дээр дарж буцаж дэлгэрэнгүй хэлбэрт оруулна.



Админ цэсийг бүрдүүлж байгаа тухайн бүлгийн цэсүүдийг мөн дэлгэж доторхи цэсүүдийг харуулах, нуух зэргээр өөрчилж болно. Хэрэв тухайн бүлгийн цэс дэлгэгдээгүй тохиолдолд курсорыг ойртуулахад уг бүлгийн цэсүүдийн нэр цэрвэс гарч ирнэ.













WordPress программын админ цэсийн бүтэц

Самбар бүлгийн цэсүүд

 Самбар	Нүүр хуудас Шинэчлэл
--	-------------------------

Агуулгын бүлгийн цэсүүд

 Бичлэг	 Бичлэг	 Медиа	 Холбоос
 Медиа	Бүх бичлэг Шинийг нэмэх Ангилал Тэмдэглээ	Медиа сан Шинийг нэмэх	Бүх холбоос Шинийг нэмэх Холбоосын ангилал
 Холбоос			
 Хуудас		 Хуудас	 Сэтгэгдэл
 Сэтгэгдэл		Бүх хуудас Шинийг нэмэх	

Тохируулгын бүлгийн цэсүүд

 Үзэмж	 Үзэмж	 Плагин	 Хэрэглэгчид
 Плагин	Загвар Виджет Цэс Загварын сонголт Толгой Дэвсгэр Код засагч	Суусан плагин Шинийг нэмэх Код засагч	Бүх хэрэглэгч Шинийг нэмэх Таны профайл
 Хэрэглэгчид			
 Багаж		 Багаж	 Тохиргоо
 Тохиргоо		Багажууд Импортлох Экспортлох	Ерөнхий Бичих Унших Ярилцлага Медиа Нууцлал Оноосон холбоос



WordPress программыг монгол хэл дээр ажиллуулахад хэрэглэх файлын орчуулга бүрэн хийгдэж дуусаагүй юм.

Одоо орчуулсан зарим нэр томъёо нь дахин өөрчлөгдөж болохыг анхаарна уу.

Жишээ нь: **Post**-ийг **Бичлэг, Нийтлэл** гэж орчуулагч нар орчуулсан бол, **Dashboard**-ыг **Самбар, Хурдан Самбар**, мөн **Category**-ийг **Бүлэг** буюу **Ангилал** гэж орчуулсан.

Энэ мэт ялгаатай орчуулгуудыг харгалзан үзнэ үү.

Аль нэг цэсийн бүлгийн нэр дээр дарахад уг бүлэгт багтах цэсүүдийн нэр гарна. Өөр бүлгийн цэсийн нэр дээр дарахад өмнөх бүлгийн цэс хураангуй хэлбэрт орж доторх цэсүүдийн нэр харагдахгүй болно..



WordPress дээр шинээр плагин суулгасан тохиолдолд тохиргоо хийх болон ажиллуулах шинэ цэс админ цэс дээр нэмэгдэн бий болно. Плагин ажиллуулах цэс Тохиргооны бүлэг дотор (Тохиргоо болон Багаж бүлэг дотор) ихэвчлэн байрлана. Эсвэл админ цэсийн эцэст байрлана.

4.2.5 Вэбийг удирдах, ажиллуулах хэсэг

Админ вэб хуудасны энэ хэсэгт вэб сайтыг ажиллуулах виджетууд байрлана. Админы аль цэсийг дарж ямар хуудас дээр ажиллаж байгаагаас хамааран энэ хэсэг дээр гарч ирэх виджетүүд өөр өөр ажил гүйцэтгэнэ. Жишээ нь Бичлэг оруулах хуудас дээр бичлэг оруулахтай хамаатай виджетүүд, Тэмдэглээ шинээр оруулах хуудас дээр тэмдэглээтэй холбоотой виджетүүд гарч ирнэ.


4.2.6 Төгсгөл

Төгсгөл хэсэгт WordPress.org вэб сайт руу орох холбоос байрлана. Мөн WordPress-ийн ямар хувилбарыг хэрэглэж байгааг энэ хэсгээс мэдэж болно.

5-р бүлэг

Админы Самбар бүлэг

- 5.1 Самбар хуудас
- 5.2 Шинэчлэл хуудас




5-р бүлэг. Админ вэб хуудасны самбар бүлэг

Админ вэб рүү нэвтрэн орох бүр дэлгэц дээр хамгийн түрүүнд Админ вэб сайтын Самбар(Dashboard) хуудас гарч ирнэ.


5.1 Самбар хуудас

Самбар(Dashboard) хуудсыг Админ вэб сайтын нүүр хуудас гэж хэлж болно. [Зураг-5.1]

Самбар(Dashboard) хуудас дээр 8 виджет байрлана. Виджетүүд дээр WordPress вэб сайт болон WordPress программтай холбоотой шинэ мэдээллүүд гарч ирнэ. Самбар(Dashboard) хуудас руу анх ороход эдгээр 8 виджет нь бүхлээрээ харагдах бөгөөд виджетийн нэр байгаа бар дээр дарж хураангуй хэлбэрт оруулж болно.



[Зураг-5.1]
Самбар(Dashboard) хуудас



Мөн дахин дарж дэлгэрэнгүй хэлбэрт оруулахаас гадна хулганаар уг нэрийн бар дээр дарж байрлалыг өөрчилж зөөж болно.

[Дэлгэцийн сонголт](#) (*Screen Options*) панелын тусламжтайгаар зөвхөн хэрэглэх виджетүүдээ

дэлгэц дээр гаргаад, ашиглахгүй бусад виджетүүдийг түр зуур харагдахгүй болгоно. Хуудас дээр хийсэн өөрчлөлтүүд нь автоматаар хадгалагдах бөгөөд хуудсыг дараа нь дахин нээхэд хамгийн сүүлд ашиглагдаж байснаараа гарч ирнэ. Мөн зарим виджетийн нэрийн бар дээр курсорыг аваачихад тохируулга хийх холбоос гарч ирнэ.

Яг одоо	
Агуулга	Ярилцлага
37 Бичлэг	1 Сэтгэгдэл
4 Хуудас	1 Зөвшөөрсөн
11 Ангилал	0 Хүлээгдэж буй
1 Тэмдэглээ	0 Спам

Хоёр мянга арван нэг загвар, 2 виджет

Хайлтын системийг блоклосон

Та WordPress 3.4.1-г ашиглаж байна.

Яг одоо (*Right Now*) виджет дээр вэбд оруулсан агуулгуудын статистик мэдээллүүд гарч ирнэ.

Агуулга (*Content*) хэсэгт вэб сайтад орсон **Бичлэг** (*Post*), **Хуудас** (*Page*), **Ангилал** (*Category*), **Тэмдэглээ** (*Tag*) үгийн нийт тоог харуулахаас гадна эдгээр үгүүд нь холбоосууд тул тэдгээр дээр дарж хамаатай админ хуудас руу орно.

Хэлэлцүүлэг (*Discussion*) хэсэгт вэб сайтад оруулсан **Сэтгэгдэл** (*Comment*)-үүдийн нийт тоо, үүнээс **Батлагдсан** (*Approved*), **Хүлээгдэж байгаа** (*Pending*) байгаа болон **Спам** (*Spam*) байж болзошгүй сэтгэгдлүүдийн тоог харуулна.

Виджетийн доод хэсэгт вэб сайтад одоо ашиглаж байгаа **вэб загварын нэр**, нийт **виджетийн тоо**, **WordPress** программын одоо ашиглаж байгаа **хувилбарыг** мэдээлнэ. WordPress-ийн шинэ хувилбар гарсан тохиолдолд уг хувилбарыг татаж суулгахыг сануулсан бичиг нэмж гарч ирнэ.



Шинэ сэтгэгдлүүд (*Recent Comments*)

Виджет дээр вэб сайтад шинээр орсон сэтгэгдлүүд гарч ирнэ. Аль нэг сэтгэгдэлд курсорыг ойртуулахад дор нь **Батлахыг үл зөвшөөрөх** (*Unapprove*), **Хариу өгөх** (*Reply*), **Засах** (*Edit*), **Спам** (*Spam*), **Хогийн сав** (*Trash*) холбоосууд гарч ирнэ. Холбоосууд дээр дарж тохирох үйлдлийг хийнэ.

Шинэ сэтгэгдэл	
	Бичсэн byamba Уулынхны нүүдэл # дээр Энэ бол сэтгэгдэл. Үл зөвшөөрөх Хариулах Засах Спам Хогийн сав
Бүх Хүлээгдэж буй (0) Зөвшөөрсөн Спам (0) Хогийн сав (0)	


Виджетийн доод хэсэгт вэбд орсон [Бүх сэтгэгдэл\(All\)](#), үүнээс [Хүлээгдэж байгаа \(Pending\)](#), [Батлагдсан \(Approved\)](#), [Спам\(Spam\)](#), [Хогийн сав \(Trash\)](#) -нд байгаа буюу одоогоор вэб сайтаас устгагдсан нийт сэтгэгдлийн тоог мэдэж болно. Энэ тоо нэрүүдийн хажуу талд хаалтан дотор гарсан байна.

Виджет дээр гаргах сэтгэгдлийн тоог өөрчлөхийн тулд виджетийн нэрийн баруун талд гарч ирэх [Тохируулах\(Configure\)](#) холбоосыг дарна. Гарч ирэх жижиг цонх дээрхи [Харуулах сэтгэгдлийн тоо \(Number of comments show\)](#) нүдэнд виджет дээр гарч ирэх сэтгэгдлийн тоог бичнэ.



Шинэ ноорогуд (Recent Drafts)

Виджет дээр вэб сайтад нийтлэгдэж амжаагүй ноорог болон хадгалсан бичлэгүүд гарч ирнэ. WordPress-ийг дөнгөж суулгаад энэ хуудас руу ороход виджет дээр ноорог бичлэгүүд гарч ирэхгүй.



Шуурхай нийтлэх(QuickPress)

Вэб дээр шинэ бичлэгийг [Шинэ бичлэг нэмэх\(Add New Post\)](#) хуудас руу орж үүсгэнэ. Хэрэв бичлэгийг яаралтай оруулах шаардлага гарвал энэ виджетийг ашиглах боломжтой. Оруулж байгаа бичлэгийг ангилах, түүнийг вэб дээр нийтлэх сар өдрийг төлөвлөх боломжгүй бөгөөд оруулсан бичлэгийг ноорог болгон хадгалах эсвэл шууд вэб дээр хэвлэнэ.




Ирсэн холбоосууд (Incoming links)

[Google блог](#) гэх зэрэг хайлтын технологийн тусламжтайгаар таны вэбтэй холбогдсон холбоосууд энэ виджет дээр гарч ирнэ. Хамгийн сүүлд үүссэн холбоос хамгийн эхэнд байрлана. Холбоосууд дээр дарж вэб сайт дээрээ нийтлэгдсэн бичлэгүүдийн тухай болон вэб сайтын тухай бусад хүмүүсийн санаа бодлыг мэдэж авах болно.

Плагиноуд (Plugins)

Виджет дээр WordPress-д зориулан Шинээр бүтээгдсэн ([Newest Plugins](#)), Саяхан шинэчлэгдсэн([Recently Updated](#)) болон хамгийн түгээмэл ([Most Popular](#)) плагиноудын мэдээлэл байрлана.



WordPress блог (WordPress blog) болон WordPress-ийн бусад мэдээ (Other WordPress news)


Эдгээр виджетүүд дээр WordPress программын талаархи сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлүүд гарч ирнэ.

WordPress Блог	WordPress-ийн бусад мэдээ
<p>Year of the Meetup January 27, 2012 We hereby declare 2012 as the Year of the WordPress Meetup. You'll want to get in on this action. So what is a WordPress Meetup? Basically, it's people in a community getting together — meeting up — who share an interest in WordPress, whether they be bloggers, business users, developers, consultants, or any other category of person able to say, [...]</p> <p>Internet Blackout Day on January 18 January 17, 2012 WordPress.org is officially joining the protest against Senate Bill 968: the Protect IP Act that is coming before the U.S. Senate next week. As I wrote in my post a week ago, if this bill is passed it will jeopardize internet freedom and shift the power of the independent web into the hands of corporations. [...]</p>	<p>WPTavern: WP Pro Business Giving Away \$9,000 Worth Of WP Stuff</p> <p>Weblog Tools Collection: WordPress Plugin Releases for 2/19</p> <p>Matt: Cats Make You Crazy</p> <p>WPTavern: Your Chance To Work With WordPress In Oslo, Norway</p> <p>Weblog Tools Collection: WordPress Theme Releases for 2/17</p>

5.2 Шинэчлэл хуудас

WordPress программын шинэчлэл, шинэ хувилбар программ, вэб сайтын дизайнд сонгосон вэбийн загвар, плагины шинэ хувилбар гарах болгонд Админ цэс дээр байгаа [Шинэчлэл\(Updates\)](#) товчны хажууд хаалт дотор тоо гарч ирнэ. Хэрэв уг товчны хажууд ямар нэгэн тоо гарч ирээгүй бол одоогоор WordPress программд шинэ өөрчлөлтүүд хийгдээгүй байна гэсэн үг.

[Шинэчлэл\(Updates\)](#) товчийг дарж уг хуудас руу орно. Хуудасны эхэнд WordPress программыг шинэчлэх шаардлагатай эсэх, программын хамгийн сүүлийн хувилбарыг ашиглаж байгаа эсэх зэрэг мэдээлэлүүд гарч ирнэ.



WordPress шинэчлэл

Хамгийн сүүлд 8 сар 27, 2012 10:23 орой цагт шалгасан. [Дахин шалгах](#)

Та WordPress-ийн хамгийн сүүлийн хувилбарыг ашиглаж байна.

Та WordPress-ийн хамгийн сүүлийн хувилбарыг ашиглаж байна. Та шинэчлэх шаардлагагүй. Хэрвээ та 3.4.1–en_US хувилбарыг дахин сулгахыг хүсвэл, автоматаар эсвэл багцыг татаж аван энгийн аргаар суулгаж болно:

[Одоо дахин сулгах](#) [3.4.1–en_US-г татаж авах](#)

Та WordPress 3.4.1-ийн **анали (АНУ)** хэл дээрх хувилбарыг суулгах гэж байна. Энэ шинэчлэл нь таны орчуулгыг гэдэж болзошгүй. Иймээс та өөрийн хэл дээрхи хувилбар өөртөл хуульчлалыг шүүж үзэж болно.

Вэб сайтын шинэчлэлт хийгдэж байгаа үед шинэчлэлтийн горим дээр байна. Шинэчлэлт дуусмагц буцаад хэвийн ажиллах болно.

Плагин

Таны бүх плагинууд шинэчлэгдсэн байна.

Загвар

Таны бүх загвар шинэчлэгдсэн байна.

Хуудас дээр ашиглаж байгаа вэб загвар болон плагинуудын хамгийн сүүлчийн хувилбаруудыг хэрэглэж байвал энэ тухай мэдээлэл бас гарсан байна.

Хэрэглэж байгаа вэб загвар, плагин бүрийн шинэ хувилбар гарсан тохиолдолд шинэчлэх шаардлагатай санамж бичиг гарч ирнэ.